

# Өөлдийн гэгээн хэмээгдсэн Цагаан гэгээн Гунгаажалцан болон Алтайн Шар сүмийн Өөлдийн тухай аман түүх

Ондрей Срба (Ondřej Srba), БНЧУ-ын Масарикийн Их Сургууль

Masaryk University, Faculty of Arts, Department of Mongolian, Korean and Vietnamese Studies

“Монголын нүүдэлчин малчдын дасан зохицох арга барилын хувирал өөрчлөлт: Нутгийн түүх болон нүүдэл суудлын хэвшил хувиралтыг аман сурвалжаар баримтжуулах нь”

“Changing Adaptive Strategies of Mobile Pastoralists in Mongolia: Dynamics in Community Histories and Movement Patterns Documented Through Oral Sources” (Czech Science Foundation, JUNIOR STAR GM23-07108M) төслийн хүрээнд бэлтгэв.

# Цагаан гэгээний ирэл гарал

Цагаан гэгээн Гунгаажалцан (Тө. bla ma dkar po kun dga' rgyal mtshan, 1835–1895) 19-р зууны хоёрдугаар хагаст Манж Чин гүрний баруун хязгаар дахь тус улсын ноёрхлыг хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэсэн шашин төрийн зүтгэлтэн.

Одоогийн Гансу мужийн Цонэ гэдэг газарт Төвд айлд төрсөн Гунгаажалцан 1852, 1862 онд анх удаа одоогийн Шинжааны Торгуудын дунд ном айлтгахаар ирэв.

# Тарвагатайд байгуулсан баатарлаг үйлс

1865 онд Тарвагатайн Хотон болон нэг хэсэг Казах бослого гаргаж Тарвагатай хотыг дайран цохиж манжийн амбаныг алав. Тус үйлдэл Тарвагатайн бус шашны оршин суугчдын дургүйцлийг хүргэж Тарвагатайн алтны уурхайн ахлаач Лю Гуан Ху хэдэн зуун уурхайн ажилчдыг дагуулж Чин улсын цэрэгт тусалсан ч босогчдод дийлэгдэж уурхай эвдэгдэв. Энэхүү мэдээг тухайн үед Тарвагатайн орчимд номын ажлаар явж байсан Гунгаажалцан хэдэн зуун лам хувраг, Эмээл голын хөвөө дэх арван суман Өөлдийн 2000 гаруй цэрэг ард ба 300 шахуу хятад ардыг зохион байгуулж Чин улсын цэргийг туслав. Энэхүү тусламжид хүчирхэгжиж Чингийн цэрэг Тарвагатай хотыг хамгаалж чадав. Тус гавьяаг үнэлж мөн оны 10-р сард Бүрэн Засагч хаан Гунгаажалцаныг хутагтаар өргөмжлөв. Тухайн үед Гунгаажалцан Тарвагатайн ард түмний дунд “Цагаан гэгээн” хэмээн алдаршив.

# Тарвагатайгаас Алтайд ирсэн нь



1866 оны 4 сард Хотон цэргийг Тарвагатайг дахиад давиран цохисонд манж цэргийн ахлаач сайд Түкүр, Цагаан хутагт Гунгаажалцан нар Өөлд арван сумны ихэнх хэсэг болон 400 гаруй хятад ардыг урагшаа дагуулан авч, Алтай нурууны баруун бэл, Бууралтохойд хоргодоод очив. Гунгаажалцан цэргийн идэр залуу хүмүүсийг Чингэл голд сургуулилан бэлтгэсний дараа босогчдийг Тарвагатайгаас зайлуулаад тарнин бутарсан арван сумны Өөлдийг дахиад зохион байгуулж уг нутагт нь эргүүлэн авчрав. 1868 онд Бууралтохойд болсон хятад тариачдын үймээн самууныг өөрийнхөө Өөлд, Солон, Казах цэргээр номхотгосон тул хааны зарлигаар түүнд өөрийг нь дагаж байсан лам нар болон нэг хэсэг Өөлд цэргийг шавьд оруулж Бууралтохойн орчмын газарт хуваан нутаглуулав. Арван сумын Өөлдөөс 40 өрх Алтайд Гунгаажалцаны шавь болж үлдэв. 1871 онд манжийн хаанаас Киран голын эрэг дээр сүм хийд байгуулах зөвшөөрлийг олж авчээ. Хойно 1878 онд Цагаан гэгээн Гүр Хар-усны Торгуудын Баяр ванд залагдаж цанид дацан байгуулав.

# Алтайгаас буцсан нь

Григорий Николаевич Потанин 1876 онд Бууралтохой, Шар сүмд зочилж, Гунгаажалцан тэргүүтэн лам хуврагийг санамсаргүй байдлаар доромжилсон хэрэгт гүтгэгдсэнээс улбаатай Орос хаант улсын дипломат гомдол Гунгаажалцаны байр суурийг хэсэгчлэн бууруулж, хамаг сүүлд Алтайгаас Хар-Ус, дараа нь Гансу мужид буцахад хүргэжээ (Sükei 2004 in *Ili-in soyol tüükiin materiyaliin mongyol ündüsüteni tusxai emkidkel* 2004, pp. 738–743, Zhao Tonghua 2014, pp. 125–126).

# Бичгийн сурвалжийн тойм

Güngaļalcan's Tibetan biography composed by Skal bzang legs bshad (whose biography and function is not known) in 1905 (*rje btsun byams pa mthu stobs kun dga' rgyal mtshan gyi rnam thar* "The life-story of Rje btsun Byams pa mthu stobs Kun dga' rgyal mtshan]") was also translated into Chinese (Gasanglexie 2002).





# Ном зүй

- GASANGLEXIE 噶桑勒协, 2002, *Chahan hutuketu Gungajalezan zhuan* 察罕呼图克图袞噶嘉勒赞传 [Biography of Čayan qutuytu Güngyaljalcan]. Translated by Wu Diao 吴钧. Gansu renmin chubanshe, Lanzhou.
- *ILI-IN SOYOL TÜÜKIIN MATERİYALIIN MONGĠOL ÜNDÜSÜTENI TUSXAI EMKIDKEL* [A Special Collection of Cultural and Historical Materials to the Mongolian Nationality in Ili], 2004, Šinĵiyang-giyin aradiyin keblel-in xorō, Ürümči,
- SKAL BZANG LEGS BSHAD, 1994, *Rje btsun Byams pa mthu stobs Kun dga' rgyal mtshan gyi nam thar* [The life-story of Rje btsun Byams pa mthu stobs Kun dga' rgyal mtshan]. Krung go'i bod rig pa dpe skrun khang, Pe cin. Accessible also at BDRC (Buddhist Digital Resource Center database) <http://purl.bdrc.io/resource/MW30295> [Accessed 01.07.2022].
- SÜKEI, 2004, *Gungyaľalcan (Cayān gegēn)* [Gungyaľalcan (Cagaan gegeen)]. In: *Ili-in soyol tüükiin materiialiin mongyol ündüsüteni tusxai emkidkel* 2004, pp. 738-743.
- YONGDAN, Lobsang, 2019, The Invention of a Tibetan Lama General: a Biographical Account of Bla ma dkar po (1835–1895). In: *Revue d'Etudes Tibétaines* 49, pp. 67-92.
- ZHANG RONG 张荣 – WANG XILONG 王希隆, 2002, Qing mo Ke Ta jiedi zhi zheng shu lun 清末科塔借地之争述论. In: *Zhongguo bianjiang shi di yanjiu* 中国边疆史地研究 March 2002, Vol. 12, No. 1, pp. 22-37.
- Zhao Tong Hua 赵桐华, 2014, *Wei jiang yingxiong – Gungazhalecan hutuketu* 卫疆英雄—棍噶扎勒参呼图克图 [The Hero of the Oirad Frontier – Kun dga' rgyal mtshan hu thog thu]. Gansu Minzu Chubanshe, Lanzhou.
- ZHAO TONGHUA 赵桐华, 2014, *Wei jiang yingxiong – Gungazhalecan hutuketu* 卫疆英雄—棍噶扎勒参呼图克图 [A Hero of the Oirad Frontiers – Gungyaľalcan qutuytu]. Gansu minzu chubanshe, Lanzhou.

# Алтайн Урианхай, Захчин, Булганы Торгуудын аман уламжлал ба Цагаан гэгээн

Шар сүм нь Алтайн Урианхайчуудын чухал мөргөлийн, худалдааны хийгээд засаг захиргааны төв болсон тул Цагаан гэгээний тухай ойлголт Алтай Урианхайчуудын дунд түгээмэл дэлгэрч, аяндаа домог зүйн шинжтэй дүр болж хувирчээ. Тус явцын дунд Цагаан гэгээний домог зүйн дүрийг бүрэлдэхэд Ойрдын дундах Амарсанаагийн дахин ирэлтийн тухай ойлголт, Цагаан аав, Цагаан өвгөний шүтлэг зэрэг үзэл санааны ухагдахуун нөлөөлжээ. Алтайн Урианхайчууд Цагаан гэгээнийг ихэнхдээ “Өөлдийн гэгээн” гэж тодотгодог атал бурханчилж шүтсээр ирсэн түүхтэй. Алтайн Урианхайчууд Цагаан гэгээнийг ирээдүйд дахин ирж урьдын дайснаасаа өшөөгөө авч, өөртөө сүсэгтэй байсан Урианхай буюу ерөнхийд нь Монгол ард түмнийг аварч хамгаална гэсэн түгээмэл хүлээлт буй болсон ч тэр нь газар газрын түүхийн аман уламжлалд тус тусын онцлогтой хадгалагдсан байгаа юм.



1862–1877 оны үед явагдсан Дунганы (Хотонгийн) болон Уйгарын бослогын улмаас Тэнгэр уул, Зүүнгарын говийн эргэн тойрон сууж байсан Торгууд, Өөлд, Хошууд, Алтай Урианхай зэрэг Монгол болон Мусульман бус бусад угсааны бүлгүүд (Шивээ, Манж, Хятад) дарлагдаж, зарим нь дүрвэж явахад хүргэгджээ.

Дунганы бослогын цэргийн довтолгооны Халх болон Ховдын амбаны харьяат газарт нөлөөлсөн үр дагаврыг хараахан дэлгэрэнгүй тайлбарласан судалгаа байхгүй ч Ойрад олон хошууны хүн ам энэ цаг үед ихээхэн ядуурсан гэж судлаачид үздэг.

Зүүнгар хаант улсын мөхөлтөөс эхэлсэн энэхүү үе үеийн уналт доройтлын нөхцөл байдал дор Ойрдууд алдар суут өнгөрсөн үеийн баатруудынхаа эргэж ирэх зөгнөлийн хүлээлтийн хэд хэдэн хэлбэрийг бий болгожээ (Амарсанаа эргэж ирэх тухай, Явган мэргэний эргэж ирэх тухай г.м.). Ийм сэтгэлгээний орчимд, Дайчин гүрний баруун хязгаар буюу одоогийн Шинжааны хойд хэсгийн 19-р зууны хоёрдугаар хагасын түүхэнд чухал үүрэг гүйцэтгэсэн Цагаан гэгээн Гунгаажалцан алдаршсан шашин, төрийн зүтгэлтний дүр түүхийн аман дурсамж уламжлах явцдаа домог зүйн шинжтэй болж хувираад Цагаан гэгээн гэдэг бурхан ирээдүй цагт ирж Монгол угсаатан ястнуудыг авран хамгаална гэсэн зөгнөлийн хүлээлт буй болов. Цагаан гэгээний талаарх тус домог зүйн ойлголт Алтай Урианхай, Захчин бөгөөд Булганы Торгуудын дунд өнөө үе хүртэл түгээмэл тархсан байдаг.

# Алтайн Урианхай, Захчин, Булганы Торгуудын аман уламжлал ба Цагаан гэгээн

Аман уламжлалд Гунгаажалцаны түүхэн дүр төрх нь түүний хоёр дахь ирэлтийн тухай зөгнөлийн хүлээлт болж хувирав. Цагаан гэгээний ирээдүйн эргэн ирэлтийн хэтийн төлөв нь Алтайн Урианхай, Захчин, Булганы Торгуудын 19-р зууны түүхэн Цагаан гэгээн Гунгаажалцантай харилцсан туршлага дээр суурилж байв. Гэхдээ, Алтайн Урианхайчуудын ихэнх хэсэг түүхийн Цагаан гэгээнтэй биечлэн уулзаж, хамт байлдаж яваагүй, түүний шавийн захиргаанд ч багтаагүй болохоор түүний түүхийн дүр төрх илүү амархан мартагдав.

Тийм маягийн шууд бус туршлагын хувьд Цагаан гэгээн нь Буддын шашинт Манж-Монголын соёл иргэншлийг тэрс буруу үзэлтэн, лалын шашинтнуудын эсрэг дэмжигч гэдгээрээ ойлгогдож байв.

# Алтайн Урианхай, Захчин, Булганы Торгуудын аман уламжлал ба Цагаан гэгээн

Алтайн Урианхай, Захчины хувьд лалын шашинт хүмүүсийг гэвэл бослогын гол оролцогч Түркэстаны Түрк буюу Уйгар, хятад хэлт Хотонгоос илүүгээр зэргэлдээ, холилдон сууж байсан Казахаар төсөөлөгдөж байв. Үнэн хэрэг дээр, “Тарвагатайн гэрээ”-ний улмаас 1860-аад оны үед Орос хаант улсын ноёрхолд орсон газраас дүрвэсэн Казахуудыг Гунгаажалцан шавьдаа оруулж дэмжээд Алтайд шинэ нутгийг олгуулахад туслав. (Zhang Rong – Wang Xilong 2002, pp. 29–30). 1860-аад оны үед Казахуудыг нутаглуулсан газрууд Алтайн Урианхайн эзэмшлийн газраас таслагдаж байсан болохоор Алтайн Урианхайчууд аяндаа бэлчээрийн хомсдолд орч эхлэв.

# Цагаан гэгээний эргэж ирэх нь

Цагаан гэгээн буюу Цагаан хутагтын дараачийн төрлүүд Алтай Урианхай, Захчин, Торгуудтай бодит холбоогүй байсан болохоор Гунгаажалцаны түүхийн дүр амархан мартагдахад хүрчээ. Урианхайчууд Цагаан гэгээний дүрийг Казахуудын эсрэг тэмцэгч гэсэн утгаар уламжлуулж эхлэв. Аман яриагаар бол Цагаан гэгээний Казахуудтай хийсэн тулаан амжилтгүй болсон тул тэр бээр ирээдүйд дахин ирж Казахуудаас өшөөгөө авах учиртай. Эхний шатны ойлголтын хувьд, Цагаан гэгээний дахин ирэлт бол түүний хойд төрлийн үед болох явдал. Гэвч хоёрдугаар шатанд, аман сэтгэлгээ түүхийн нөхцөл байдлаас улам холдоод ирэх тусмаа Цагаан гэгээнийг тодорхой цаг үетэй холбоогүй бурхан хэмээн ойлгож эхэлсэн тул түүний өмнөх дүрийн үйл явдал ч гэсэн 100-аад жилийн өмнөх явдал бус, аль эртний явдал мэт ойлгогдох болжээ.

# Цагаан гэгээний бага насны тухай аман уламжлал

Алтайн Урианхайчуудын хувьд, Цагаан гэгээний тухай өгүүлэмж Амарсанаа, Чингис хаан зэрэг бусад түүх, домгийн баатруудын хүүрнэлийн зарим сэдвийг зээлж ашиглав. Жишээ нь, Баян-Өлгий аймгийн Булган сумын С.Балдаагийн өгүүлснээр Цагаан гэгээн:

*нэг төрөлдөө Цагаан гэгээн ээжтэйгээн байгаад ээж нь гараад үхэр саагаад үс (=суу) гэрт оруулаад үхэр тавьчхаад туглаа тавьж хөхүүлээд ороод иртэл тэр [Цагаан гэгээн] үс ус руу хийчихсэн тэгээд ялгаж байж гэнэ. Ээж нь уурлаад “Яаж байдаг чи?” - “Ээжээ, намайг битгий уурлатан, би дэлхий хорвоо дээр эргэж ирэхэд энэ Халх Хасаг хоёр нэгдэж одсон байх. Түүнийг яажил байна, түүнийг шалгаж байна би. Энэ үсийг чинь ялгаад үс ус хоёрыг ялгаад байхаар тэр үед би ялгаж чадна. Түүнийг би ялгаж чадахгүй бол чадахгүй. Битгий уурла.” Энэ цаг чинь дөхөж явна.*





# Цагаан гэгээн Казах хүнд өшөөтэй болсон тухай аман уламжлал

Шинжааны Чингэл шиянд Алтайн Урианхайчуудын дунд Цагаан гэгээний тухай хамгийн дэлгэрэнгүй түүхийг над Жин Танзи (1927-?) гуай ярьж өгөв. Тэр бээр АУ-н Баруун амбаны Мянгат сумын хүн боловч өвөг аавынхаа үеэс Алтайн Шар сүмийн дэргэд Өөлдийн хамт амьдарсан ба өөрөө бас тэнд төрсөн билээ. 1940-өөд оны үеийн Оспаны дайнаас болж Өрөмч, Жимсайрын орчимд, цааш нь Чингэлд шилжиж ирэв. Түүний ярианы эцэст Цагаан гэгээн Алтайгаас буцахдаа нэг Казах баатраар алагдах эрсдэлээс номын чадлаараа өөрийгөө хамгаалсан гэсэн сонин аман мэдээ байна.





*Цагаан гэгээн Тарвагатайн Өөлд, Өөлд ястай күмн. Өөлдийн гэгээн Цагаан гэгээн болныш. Алтайн Шар сүмийг бариулсан. Цагаан гэгээнээ байр нь тэр Алтайн Шар сүм гэж кэлдэн билээ урьд. ...*

*Гэгээнтэн хойний биднүүсийн сонсворт дакаад цаар эх нутагтаа харьсан. Тэр цаар нутагтаа күрээ дацан байсан газартаа. Манай нэг нагац байсан тэр кэлэхдээ [Цагаан гэгээн] хойний дакаад өмөөр халаагаад явж л, өмөөр хамаар одсон мэдэхгүй, энэ Тулт гэдэг газраар давираад гарахад, тэр Тулт гэдэг газрыг давираад гарахад өмнөөсий хасаг тосч аваад алдаг гэгээд энэ күмийг. Гэгээн их номтой күчтэй, гэгээн их номтой күн болж байна. Ямар гэдэг хасаг? Тэр намайг алагш. Тэр алнам гэсэн хасаг ямар гэдэг хасаг гэж сурсан болж байна. Тэр хамт дахсан күмээс асуудаг байж. Хар Осмаан гэдэг баатар хасаг, энэ чамайг алнам гээд өмнө хүм тосчихсон байна. Оо, болна, болна, тэр намайг алж чадагш гээд. Тэндээ сууж байгаад ном умшаад, хариулсан байна тэрийг, тэр хасаг алж чидалгүй өнгөрсөн байна. Тэр одоо зууз [=жууз] гэдэг билээ күм сууж өргөдөг, тэр зуузаар явж байсан күмн билээ өмөөрөө халаагаад. Энэ нутгаас яагаад явж одваа гэхлаар Нутагтаа баахан гомдаад. Тэгээд явсан күмн гэж кэлдэг жиг. Тэр нутаг баахан санаагаар тааруу болдог жиг. Тэр күмийг гүй кийдэг баахан дораагуур гүвээ гүйлгээд одаа. Тэхлээр тэр күмэнд энд бидэн байж бологш. Миний цаг ч одаа харидаг цаг боллаа. Тултын экэнд улаан уул байна, Тултын Улаан уул, Түүний экэн дээр ирээд амарч аваад, нэг цай чанаж уучхаад, түүнээс хоораан явсан гэнэ. Үүнээс хоораан тэр хүм хамаа одсон, ямар ажил кийсэн чухам бид мэдэкш.*

Ойролцоо утгатай хүүрнэлийг бас Булган сумын С.Балдаа гуай ярьсан бөгөөд түүний хувилбар Амарсанаагийн ялалтын тухай домогтой хэд хэдэн ижил талыг агуулж байна.

Цагаан гэгээнийг Казах ноёнд баригдсанд тэр нь түүнийг ерөөл тавихыг шаардав. Цагаан гэгээн түүнд хүчтэй ерөөл хэлсэн ч, Казахын ноён түүнийг хуурч суллаж өгсөнгүй. Тэгээд Цагаан гэгээн мэхлэгдсний хариуд Казах ноёны эзэлсэн нутгийг харааж

*модон чинь хувхайрч одоод*

*усан чинь тасарж одтугай* гэж айлтгав.

Дараа нь Цагаан гэгээн өөрийгөө эргэж ирнэ, өшөөгөө авна гэсэн утгатай ерөөлийг тавьжээ.

*За, дахиад модон чинь хуучин хэвт очиж ургаад*

*усан чинь голд очиж нийлээд*

*цоохор морины сүүл газарт хүрээд*

*тавилхай дөрөөнд хүрээд* (– тавилхай гэж модон байна малиан иш хийдэг)

*тэр цагт би эргэж ирнэ.* (Baldaa 2013. 6. 16. WS560925 29:43.)

Энэхүү өгүүлэмж нь Амарсанаагийн тухай алдарт домогт газрыг хараах сэдэвтэй маш ойр (Баттогтох 1991, 112–114. Баттулга 2006, pp. 550–553. Баттулга 2013, pp. 281–282.) Амарсанаа Манжийн хаанд ялагдсан ч манжийн цэргээс зугтсанд Манжийн хаан тулаан болсон газар буюу Бүргэдтэй гол, уулыг хараасан гэнэ. Тэгээд тухайн хараал уул усанд нөлөөгөө алдах буюу уул ус сэргэж ирэх цагт Амарсанаа эргэж ирж Ойрдуудаа аварна гэсэн домог.

Өмнөх жишээнд дурдсанчлан, Алтайн Урианхайчууд Цагаан гэгээний хоёр дахь ирэлтийг урьдчилан таних тодорхой шинж тэмдэгтэй холбож үздэг. Эдгээр шинж тэмдгүүдийг олон янзын байдлаар хэлдэг бөгөөд ихэнх нь цагаан өнгийн бэлгэдлийг агуулдаг. Дашрамд хэлэхэд, Урианхайчууд *цагаан* гэсэн үгийг цээрлэж, *гилээн* гэсэн үгээр орлуулах заншил зарим тохиолдолд Цагаан гэгээнд үзүүлдэг хүндэтгэлээс үүдэлтэй гэж тайлбарладаг.

Жин Танзи өвгөн:

*Урьд хуучин кокшчууд кэлэхдээ Цагаан гэгээн тодорхула дакаад нутагтаа эргэж ирнэ.*

*Нутагтаа кэлээд явсан юмий тэр:*

*Тавилхай дөрөөд күрхэд*

*Цоохор морины сүүл газар күрхэд гэдэргээ эргэнэм.*

*... Одоо биенээний кэлж байсан үнэн болжим одаа ирхэлгүй.*

Булган сумын Балдаа гуай өөрөө Цагаан гэгээнийг:  
*хасгийн гэр цагаан болоод*  
*хой (=хонь) нь цагаан болоод ийм цагт эргэж ирнэ*  
гэсэн байна.



# Цагаан гэгээний дахин ирэлтийн шинж тэмдэг

Дээрх шинж тэмдгүүдийг авч үзвэл, Алтайн Урианхайчууд Цагаан гэгээний эргэж ирэх цаг ойртсон байна гэж удаа дараа дүгнэж байсан. Олон алаг морины сүүл газарт хүрсэн. Казахууд Монголчуудын адил цагаан бүрээстэй гэрийг хэрэглэх болсон. Казахууд цагаан хонь үржүүлдэг, хар нохой тэжээдэг болсон гэх мэт шинж тэмдгүүд одоо үнэн болсон гэж хүмүүс ярьж байдаг. Юуны өмнө, Казах ч гэсэн, Монгол ч гэсэн одоогийн үед элбэг хоол, хүнс, аливаа хэрээглээний эд бараатай болсон. Хэдэн зууны турш ядуувтар байсан Алтай нууруунд “бүх юм элбэг болох цаг үе” бол заавал ямар нэгэн цагийн эргэлтийг бэлгэдсэн гэж өндөр настайчууд үздэг. Магадгүй, энэ бол Цагаан гэгээний эргэж ирэх болсны шинж.

Гэвч зарим хүмүүс Цагаан гэгээний дахин ирэлтийн тухай илүү ер бусын шинж тэмдгүүдийг бас ажиглав гэж ярьдаг. С.Балдаа гуай нэгэн удаа ууланд ан хийж явтлаа хээр гадаа нэг уяатай эзэнгүй морийг анзаарчээ. Эзнийг нь хайж байтал морь өөрөө алга болжээ. Балдаа энэ үзэгдлийг Цагаан гэгээн ирж буйн шинж гэж үзжээ. (Baldaa 16. 6. 2013. WS560925 33:47.)

Цагаан гэгээн эргэж ирэхдээ Казахуудаас өшөө авна гэхээс биш, Монголчууд хөндөгдөөгүй үлдэнэ гэсэн нийтлэг ойлголттой байдаг. Цагаан гэгээн Монгол айлуудыг гэрийн үүдний урд байрлах, сан тавих гурван давхар чулуугаар танина гэдэг.

*Цагаан гэгээн эс байна уу? Ирээд хасгийг л авныш мэдэжбайнч? Хасагаас анги амьтанд гар хүрэхгүй. Орос, Китад, Урианхай, Захчин, Торгууд – гар хүрэхгүй, энийг л авдаг номтой түүх байна.* (Baldaa 16. 6. 2013. WS560925 29:43)



# Цагаан гэгээний дахин ирэлтийн шинж тэмдэг

Баян-Өлгий аймгийн Алтай сумын ахмад малчин Ч.Батнасан гуай Цагаан гэгээний ирэлтийг зүйрлэл маягаар тайлбарлав. Цагаан гэгээн “чулуу шиг” ургасаар байна. Өөрөөр хэлбэл, Цагаан гэгээний цагийн хувьд ойртож буй ирэлтийг энэ дэлхийд хэрэглэдэг сангийн чулууны нам өндрөөр илтгэж болно. Өнөө үед, Цагаан гэгээний өндөр бол гурван сангийн чулуутай чацуу. Гурван сангийн чулуу хүний өндөрт хүрэх цагт, Цагаан гэгээний цаг ч гэсэн боловсорч ирэх ба тэр бээр даалгасан үүргээ биелүүлэхээр ирнэ.



# Цагаан гэгээн хоёр удаа эргэж ирнэ ...

1990-өөд оны үед Шинжааны Чингэл шияны Алтайн Урианхайчуудын ярьж байгаагаар, Цагаан гэгээн хоёр удаа эргэж ирэх учиртай байсан. Тэр бээр анх удаа эргэж ирэхдээ Хятад хүнээс өшөөгөө авна гэв. Яаж өшөө авна гэхээр бүх Хятадыг нэг тогооноос хооллуулна. Тэгээд Соёлын хувьсгалын үед хоол идэх хүртэл амьдралын бүхий л үйл явц нэгдэлжих журамд орсноор бүх хятад хүн нэг тогооноос хооллож байсан гэнэ. Тэр бол Цагаан гэгээний анх удаа тухайн үеийн Хятадын удирдагчийн хувьд эргэж ирсэн тохиолдол гэнэ. Одоо нэг ирэхдээ Казах хүнээс өшөө авна.

Шинжааны Алтайн Урианхайчууд Цагаан гэгээний тухай ядаж хоёр уртын дуу дуулдаг. Гол уртын дууны үгийг түүхийн Цагаан гэгээнийг дурсан санасан дурсамж мэт ойлгож болох боловч бас түүний дараах төрлийн дахин ирэлтийн зөгнөл мэт ойлгож болно.



# Цагаан гэгээний уртын дуу

*цакир цагаан хатаду  
цагаан гэрэл бадарна  
цагаан икэ нутагту  
цагаан гэгээн тодорна л  
мөнкө цастай ууладу  
мөлөр эрдэнэ гилэвкийнэ  
манаа икэ нутагту  
цагаан гэгээн заларна*

*алтайн шара сүмэдэ  
арцна үнэр ханкилна л  
аврал икэтэй цагаан гэгээн  
ард түмэнээ хайрлатха л  
аврал икэтэй цагаан гэгээн  
өршөөж хайрлатха л*

Түтгийн Жулжа дуулав (Шинжаан, Чингэл 2008.8.18., Буян шингээв)

Тус уртын дуу Монгол улсын нутаг дахь Алтайн Урианхайчуудын дунд мартагдсан янзтай боловч Цагаан гэгээний шавь нарыг *Эрээн бүлчинтэй шархал* гэдэг уртын дуунд дурддаг.

# Дүгнэлт

Аман уламжлалын эшлэлээс харахад Цагаан гэгээний тухай аман уламжлалын дүр бэлгэдэл, зүйрлэл элбэгтэй талаараа бичмэл сурвалжаар (Цагаан гэгээний төвд намтар, архивын эх сурвалж) өгүүлсэн түүний амьдралын түүхээс эрс ялгаатай байна. Тийм боловч Цагаан гэгээний аман уламжлалын дүр түүхэн Гунгаажалцаны түүхийн бодит үндсэн дээр бий болсон юм. Аман уламжлалын Цагаан гэгээний дүрд түүхэн Гунгаажалцаны шашин төрийн үйл ажиллагаа, үзэл санааг бус Алтайн Урианхай, Захчин, Торгууд нарын өөрсдийн түүхэн туршлагыг тусгасан байна. Цагаан гэгээний тухай аман уламжлал өнөөг хүртэл нэн амьд байсаар ирсэн нь ч үүнийг баталж байна. Цагаан гэгээний аман уламжлал бол өнгөрсөн үеийн тухай биш, одоо болон ирэх цагийг илэрхийлэхийг зорьж байгаа юм.

Цагаан гэгээний талаар ойлголт, итгэл үнэмшил авралд одуулах, тусгайлан зориулж сан тавих гэх мэтийн ямарваа нэгэн сүсэг бишрэлийн хэлбэрийг бий болгоогүй боловч Оросын Алтай аймгийн 20-р зууны эхэнд дэлгэрсэн Ак-жан шашны хөдөлгөөнтэй зарим сэтгэлгээний харилцааг цаашдын судалгаанд анхаарч үзэх нь зүйтэй юм.